



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/225

Булган сум

Улсын нөөцөөс малын тэжээл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.10 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн сумдад Улсын нөөцөөс үнэгүй олгох малын тэжээлийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Хуваарилагдсан малын тэжээлийг орон нутгийн малчдад үнэгүй олгохыг сумдын Засаг дарга нарт, зориулалтын бусаар зарцуулах, дамлан худалдаалах зөрчлөөс урьдчилан сэргийлж, хяналт тавин ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Одхүү), Цагдаагийн газрын дарга (хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг) нарт тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2015 оны
04 дүгээр сарын 10-ны/ний өдрийн
А/225 дүгээр захирамжийн хавсралт

СУМДАД ОЛГОХ МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

Д/д	Сумдын нэр	Тоо хэмжээ /тонн/
1	2	3
1	Баян-Агт	7
2	Булган	7
3	Баяннуур	7
4	Бугат	7
5	Бүрэгхангай	7
6	Гурванбулаг	7
7	Дашинчилэн	7
8	Сайхан	7
9	Сэлэнгэ	7
10	Орхон	7
11	Могод	7
12	Рашаант	7
13	Тэшиг	7
14	Хангал	7
15	Хутаг-Өндөр	7
16	Хишиг-Өндөр	7
17	Хялганат	4
18	АОК	9
	НИЙТ ДҮН	125